

**ШШГЕГ-ЫН ХАРЬЯА МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2017  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Аудитын код: САГ-2018/217/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо  
Утас: 261740 Цахим хаяг: [ichinkhorloosh@audit.gov.mn](mailto:ichinkhorloosh@audit.gov.mn)

“Амгалан Ахуй Аудит” ХХК-ийн захирал Д.Амгалан  
Утас: 77011044 Цахим хаяг: [Amgalanahui.audit@gmail.com](mailto:Amgalanahui.audit@gmail.com)

Чанарын хяналтын мэргэжилтэн Б.Цэцэгмаа  
Утас: 77011044 Цахим хаяг: [Amgalanahui.audit@gmail.com](mailto:Amgalanahui.audit@gmail.com)

Аудитор Ц.Насанжаргал, Т.Ганцэцэг  
Утас: 77011044 Цахим хаяг: [Amgalanahui.audit@gmail.com](mailto:Amgalanahui.audit@gmail.com)



## Агуулга

---

|       |                                                                                  |    |
|-------|----------------------------------------------------------------------------------|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....                                                          | 0  |
| 2     | Аудитын тайлан.....                                                              | 1  |
| 2.1   | Оршил.....                                                                       | 1  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....            | 1  |
| 2.3   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....                  | 2  |
| 2.4   | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 2  |
| 2.5   | Дотоод хяналт .....                                                              | 3  |
| 2.6   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                            | 3  |
| 2.7   | Шилэн дансны мэдээлэл .....                                                      | 3  |
| 2.8   | Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....                      | 3  |
| 2.9   | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....          | 4  |
| 2.9.1 | Бараа материалын талаар .....                                                    | 4  |
| 2.10  | Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....                                       | 4  |
| 2.11  | Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....                                      | 4  |
| 2.12  | Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....                                          | 4  |
| 2.13  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                                                  | 4  |
| 2.14  | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....                       | 4  |
| 2.15  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....                                           | 4  |
| 3     | Менежментийн захидал.....                                                        | 6  |
| 3.1   | Бараа материалын талаар .....                                                    | 7  |
| 4     | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....                         | 8  |
| 4.1   | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....                                    | 8  |
| 4.2   | Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....                                 | 9  |
| 4.3   | Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....                      | 11 |
| 4.4   | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                    | 12 |
| 4.5   | Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                                  | 14 |

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА МЭРГЭЖИЛ СУРГАЛТ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ АХЛАХ  
ДЭСЛЭГЧ Х.БАТБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна

**Санал дүгнэлтийн үндэслэл**


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүгнэлтэд өгсөн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Х.Батбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн удирдлагад 2018 онд ШШГЕГ, ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулж хөрөнгийн ангиллыг УСНББОУС 17-ын дагуу залруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бодитой бэлтгэх үүрэгтэй.



Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 02-наас 2018 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Амгалан ахуй САГ-2018-/217/СТА-ТШЗ

аудит” ХХК-ийн аудитор Б.Буянтэгш, аудитор Б.Цэцэгмаа, туслах аудитор Т.Ганцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын чанарын менежер Ц.Насанжаргал гүйцэтгэж, захирал Д.Амгалан хянан удирдав.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх талаар Үндэсний Аудитын Газрын 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 03/316 дугаар албан бичгээр “Амгалан Ахуй Аудит” ХХК-д мэдэгдсэн болно.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/12 дугаар тушаалын 50 дугаар хавсралтаар ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн бүтцийг 34 орон тоотойгоор баталсан байна.

#### **ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:**


ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь барилгын цахилгаанчин, засал чимэглэлч, сантехникч, өрөгч угсрагч, гагнуурчин, бетон арматурчин, мужаан, тогоочийн сургалт явуулдаг. Тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь улсын хэмжээнд хорих ял эдлэлж байгаа хоригдлуудад “Мэргэжлийн үнэмлэх, мэргэжлийн боловсрол олгох” сургалтыг ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад болон өөрийн төвд зохион байгуулдаг болно.

#### **Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

Цагдан хорих 461 дүгээр ангийн хэмжээнд 2017 онд “ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ” зорилтыг дэвшүүлж, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 6 төрлийн арга хэмжээг үр дүнгийн гэрээ, алба нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь Хорих ял эдлэгсэдийг нийгэмшүүлэх тэдэнд ажил хөдөлмөрийн дадал чадвар эзэмшүүлж, Мэргэжлийн үнэмлэх зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зорилттой байна.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, ТАС-СТА-А-1-д баримтжуулсан.



### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 18 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамжаар бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

## 2.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн шууд захирагчийн 2017 оны төсвийн урсгал зардалд 425,067.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 425,067.6 мянган төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн Үйлэн дансны хуульд заасны дагуу, хуулийн тогтоосон хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авалт байхгүй байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

## **2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

### **2.9.1 Бараа материалын талаар**

“Ашиглалтанд байгаа хангамжийн материал” дансанд үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулсан 14,807.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь толилуулга ба илчлэл тодруулга, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй ба УСНББОУС 17-ын дагуу тайлагнаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэр гаргуулж хөрөнгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх.

### **2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

### **2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл болон ангиллыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу бүртгэсэн эсэхийг нарийвчлан шалгах нь зүйтэй.

### **2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 14,807.1 мянган төгрөгийн нэг зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

### **2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитаар өгөгдсөн зөвлөмж байхгүй байна.

### **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 432,039.9 мянган төгрөг бөгөөд 1 хувь буюу 4,320.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

### **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурдсан ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр САГ-2018-/217/СТА-ТШЗ



дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмж цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг харуулав.



**3.1 Бараа материалын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

“Ашиглалтанд байгаа хангамжийн материал” дансанд үндсэн хөрөнгийн шинж чанарыг агуулсан 14,807.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. НББ-ийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт дагаж мөрдөнө.

**Эрсдэлүүд**

Хөрөнгийн элэгдэл тооцогдохгүй байгаагаас хөрөнгийн бодит үнэ цэнэ буруу илэрхийлэн. Тайлант хугацааны зардлыг дутуу илэрхийлж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

2018 онд ШШГЕГ, ТӨБЗГ-ын шийдвэр гаргуулж хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код   | Балансын үзүүлэлт                                  | Эхний үлдэгдэл       | Эцсийн үлдэгдэл      |
|--------------|----------------------------------------------------|----------------------|----------------------|
| <b>I</b>     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>39,961,538.00</b> | <b>42,858,770.00</b> |
| <b>31</b>    | <b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>           | <b>49,574.00</b>     | <b>-</b>             |
| <b>312</b>   | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                  | <b>49,574.00</b>     | <b>-</b>             |
| 31211        | Төрийн сангийн харилцах                            | 49,574.00            | -                    |
| <b>35</b>    | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                              | <b>39,911,964.00</b> | <b>42,858,770.00</b> |
| <b>351</b>   | <b>Түүхий эд материал</b>                          | <b>2,653,050.00</b>  | <b>2,653,050.00</b>  |
| 35110        | Тусгай зориулалттай материал                       | 1,648,000.00         | 1,648,000.00         |
| 35130        | Эм боох материал                                   | 1,005,050.00         | 1,005,050.00         |
| <b>354</b>   | <b>Хангамжийн материал</b>                         | <b>37,258,914.00</b> | <b>40,205,720.00</b> |
| 35410        | Бичиг хэргийн материал                             | 1,135,770.00         | 2,357,790.00         |
| 35420        | Аж ахуйн материал                                  | 24,360,144.00        | 33,486,540.00        |
| 35430        | Сэлбэг хэрэгмэл                                    | 614,000.00           | -                    |
| 35440        | Түлш, шатах тослох материал                        | 4,373,000.00         | 2,460,000.00         |
| 35450        | Барилгын засварын материал                         | 5,398,000.00         | 1,901,390.00         |
| 35470        | Бусад хангамжийн материал                          | 1,378,000.00         | -                    |
| <b>II</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 | <b>36,701,641.70</b> | <b>37,484,666.37</b> |
| <b>39</b>    | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                              | <b>36,701,641.70</b> | <b>37,484,666.37</b> |
| <b>392</b>   | <b>Биет хөрөнгө</b>                                | <b>33,068,244.30</b> | <b>34,516,922.84</b> |
| 39203        | Авто-тээврийн хэрэгсэл                             | 63,123,000.00        | 51,123,000.00        |
| 39204        | Хуримтлагдсан элэгдэл                              | 48,273,000.00        | 40,398,000.00        |
| 39205        | Машин тоног төхөөрөмж                              | 25,873,146.00        | 36,797,656.00        |
| 39206        | Хуримтлагдсан элэгдэл                              | 14,793,315.00        | 18,950,552.22        |
| 39207        | Тавилга, эд хогшил                                 | 20,936,457.00        | 22,066,457.00        |
| 39208        | Хуримтлагдсан элэгдэл                              | 13,798,043.71        | 16,121,637.94        |
| <b>393</b>   | <b>Биет бус хөрөнгө</b>                            | <b>3,633,397.39</b>  | <b>2,967,743.53</b>  |
| 39301        | Програм хангамж                                    | 4,437,692.31         | 4,437,692.31         |
| 39302        | Хуримтлагдсан элэгдэл                              | 804,294.92           | 1,469,948.78         |
| <b>III</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | <b>76,663,179.73</b> | <b>80,343,436.37</b> |
| <b>IV</b>    | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                   | <b>49,574.00</b>     | <b>-</b>             |
| <b>41300</b> | <b>Өглөг</b>                                       | <b>49,574.00</b>     | <b>-</b>             |
| <b>41362</b> | <b>Хувь хүнд өгөх өглөг</b>                        | <b>49,574.00</b>     | <b>-</b>             |
| <b>V</b>     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | <b>38,997,652.44</b> | <b>80,343,436.37</b> |
| <b>51</b>    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 | <b>38,997,652.44</b> | <b>38,997,652.44</b> |
| 51101        | Засгийн газрын оруулсан капитал                    | 38,997,652.44        | 38,997,652.44        |
| <b>51200</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | <b>37,615,953.29</b> | <b>41,345,783.93</b> |
| 51210        | Өмнөх үеийн үр дүн                                 | 37,615,953.29        | 37,615,953.29        |
| 51220        | Тайлант үеийн үр дүн                               |                      | 3,729,830.64         |
| <b>VIII</b>  | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>76,663,179.73</b> | <b>80,393,010.37</b> |

## 4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код  | Үзүүлэлт                                              | /төгрөгөөр/           |                       |
|-------------|-------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
|             |                                                       | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
| <b>I</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                | <b>355,237,232.31</b> | <b>432,039,910.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                            | <b>361,240.00</b>     | <b>1,921,000.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                    | <b>361,240.00</b>     | <b>1,921,000.00</b>   |
| 120004      | Төсөвт байгууллагын өөрийн орлого                     | 361,240.00            | 1,921,000.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                     | 361,240.00            | 1,921,000.00          |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                  | <b>354,875,992.31</b> | <b>430,118,910.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                        | <b>353,568,300.00</b> | <b>425,067,600.00</b> |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                     | 353,568,300.00        | 425,067,600.00        |
| <b>1330</b> | <b>Төсвийн захирагчдаас</b>                           | <b>1,307,692.31</b>   | <b>5,051,310.00</b>   |
| 133003      | Хөрөнгийн                                             | 1,307,692.31          | 5,051,310.00          |
| <b>II</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                    | <b>378,917,865.10</b> | <b>428,310,079.36</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | <b>378,917,865.10</b> | <b>428,310,079.36</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | <b>378,917,865.10</b> | <b>417,375,282.35</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | <b>300,470,239.81</b> | <b>327,419,945.91</b> |
| 210101      | Үндсэн цалин                                          | 283,489,923.49        | 280,423,044.23        |
| 210102      | Нэмэгдэл                                              | 16,140,316.32         | 46,996,901.68         |
| 210104      | Урамшуулал                                            | 840,000.00            |                       |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | <b>6,166,811.46</b>   | <b>6,984,057.08</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                    | 578,888.13            | 567,736.85            |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                    | 9,015.78              | 64,884.19             |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                     | 11,269.73             | 81,105.26             |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                  | 901.58                | 480.00                |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                 | 5,566,736.24          | 6,269,850.78          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>               | <b>21,731,563.73</b>  | <b>19,753,865.00</b>  |
| 210401      | Бичиг хэрэг                                           | 1,660,720.00          | 1,937,825.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун                                      | 9,142,320.00          | 16,524,000.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернетийн төлбөр                    | 1,558,648.73          | 1,292,040.00          |
| 210407      | Аж ахуйн материал худалдан авах зардал                | 9,369,875.00          | -                     |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                               | <b>9,766,910.00</b>   | <b>15,030,000.00</b>  |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                       | 63,120.00             | -                     |
| 210502      | Хоол, хүнс                                            | 9,703,790.00          | 14,800,000.00         |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                           | -                     | 230,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>              | <b>2,010,000.00</b>   | <b>2,601,390.00</b>   |
| 210604      | Урсгал засвар                                         | 2,010,000.00          | 2,601,390.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                         | <b>3,000,000.00</b>   | <b>3,000,000.00</b>   |
| 210702      | Дотоод албан томилолт                                 | 3,000,000.00          | 3,000,000.00          |

ИШШГЕГ-ын харьяа МСҮТ-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |                                                                      |                        |                      |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------------|----------------------|
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>1,446,100.00</b>    | <b>728,800.00</b>    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,086,100.00           | -                    |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 360,000.00             | 370,600.00           |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                        | -                      | 40,000.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | -                      | 318,200.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>34,326,240.10</b>   | <b>41,857,224.36</b> |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 20,186,000.00          | 30,585,739.00        |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 14,140,240.10          | 11,271,485.36        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | <b>-</b>               | <b>10,934,797.01</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | <b>-</b>               | <b>9,374,000.00</b>  |
| 313209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | -                      | 9,374,000.00         |
| <b>2133</b> | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>            | <b>-</b>               | <b>1,560,797.01</b>  |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                | -                      | 1,560,797.01         |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>- 23,680,632.79</b> | <b>3,729,830.64</b>  |
| <b>V</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                               | <b>56,915,766.55</b>   | <b>-</b>             |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                       | 56,915,766.55          | -                    |
| <b>VI</b>   | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b>-80,596,399.34</b>  | <b>3,729,830.64</b>  |



#### 4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| /төгрөгөөр/                                  |                                 |                       |                       |                                        |
|----------------------------------------------|---------------------------------|-----------------------|-----------------------|----------------------------------------|
| Үзүүлэлт                                     | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн     | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| <b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>   | <b>38,997,652.44</b>            |                       | <b>118,212,352.63</b> | <b>157,210,005.07</b>                  |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт   |                                 |                       |                       |                                        |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>            |                                 |                       |                       |                                        |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт      |                                 |                       |                       |                                        |
| Тайлант үеийн үр дүн                         |                                 |                       | -80,596,399.34        | -80,596,399.34                         |
| <b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>   | <b>38,997,652.44</b>            |                       | <b>37,615,953.29</b>  | <b>76,613,605.73</b>                   |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт   |                                 |                       |                       |                                        |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>            |                                 |                       |                       |                                        |
| Тайлант үеийн үр дүн                         |                                 |                       | 3,729,830.64          | 3,729,830.64                           |
| <b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>38,997,652.44</b>            |                       | <b>41,345,783.93</b>  | <b>80,343,436.37</b>                   |





#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код    | Үзүүлэлт                                                        | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|---------------|-----------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                          | <b>353,568,300.00</b> | <b>425,067,600.00</b> |
| <b>13</b>     | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                            | <b>353,568,300.00</b> | <b>425,067,600.00</b> |
| <b>1310</b>   | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                  | <b>353,568,300.00</b> | <b>425,067,600.00</b> |
| 131001        | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                               | 353,568,300.00        | 425,067,600.00        |
| <b>2</b>      | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                        | <b>353,568,300.00</b> | <b>419,863,974.00</b> |
| <b>21</b>     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                            | <b>353,568,300.00</b> | <b>419,863,974.00</b> |
| <b>210</b>    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | <b>353,568,300.00</b> | <b>408,429,176.99</b> |
| <b>2101</b>   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | <b>300,031,699.98</b> | <b>326,766,400.00</b> |
| 210101        | Үндсэн цалин                                                    | 290,031,699.98        | 303,996,400.00        |
| 210102        | Нэмэгдэл                                                        | 9,000,000.00          | 20,770,000.00         |
| 210103        | Унаа хоолны нэмэгдэл                                            |                       | 1,000,000.00          |
| 210104        | Урамшуулал                                                      | 1,000,000.00          | 1,000,000.00          |
| <b>2102</b>   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | <b>6,605,351.29</b>   | <b>7,137,602.99</b>   |
| 210205        | Эрүүл мэндийн даатгал                                           | 6,605,351.29          | 7,137,602.99          |
| <b>2104</b>   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>13,985,648.73</b>  | <b>18,100,000.00</b>  |
| 210401        | Бичиг хэрэг                                                     | 1,250,000.00          | 2,307,960.00          |
| 210402        | Тээвэр, шатахуун                                                | 11,177,000.00         | 14,500,000.00         |
| 210403        | Шуудан, холбоо, интернетийн төлбөр                              | 1,558,648.73          | 1,292,040.00          |
| <b>2105</b>   | <b>Нормативт зардал</b>                                         | <b>6,690,000.00</b>   | <b>14,800,000.00</b>  |
| 210502        | Хоол, хүнс                                                      | 6,690,000.00          | 14,800,000.00         |
| <b>2106</b>   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>2,000,000.00</b>   | <b>3,846,800.00</b>   |
| 210601        | Багаж, техник хэрэгсэл                                          |                       | 846,800.00            |
| 210604        | Урсгал засвар                                                   | 2,000,000.00          | 3,000,000.00          |
| <b>2107</b>   | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | <b>3,000,000.00</b>   | <b>3,000,000.00</b>   |
| 210702        | Дотоод албан томилолт                                           | 3,000,000.00          | 3,000,000.00          |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>1,605,600.00</b>   | <b>778,374.00</b>     |
| <b>210801</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>1,245,600.00</b>   | <b>49,574.00</b>      |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар                                      | 360,000.00            | 370,600.00            |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                   | -                     | 40,000.00             |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 |                       | 218,200.00            |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | <b>19,650,000.00</b>  | <b>34,000,000.00</b>  |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                               | 19,650,000.00         | 34,000,000.00         |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                         | <b>-</b>              | <b>11,434,797.01</b>  |
| <b>2131</b>   | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>       | <b>-</b>              | <b>1,560,797.01</b>   |
| 213101        | Төвлөрүүлэх шилжүүлэг                                           | -                     | 1,560,797.01          |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                   | <b>-</b>              | <b>9,874,000.00</b>   |
| 213204        | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                  | -                     | 977,000.00            |

ШШГЕГ-ын харьяа МСҮТ-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|        |                                                                            |                  |                     |
|--------|----------------------------------------------------------------------------|------------------|---------------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                    | -                | 8,897,000.00        |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | -                | <b>5,203,626.00</b> |
| 4      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | -                | <b>5,253,200.00</b> |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                    | -                | <b>5,253,200.00</b> |
| 2200   | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                                 | -                | <b>5,253,200.00</b> |
| 225102 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | -                | 5,253,200.00        |
| 6      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | -                | -                   |
| 8      | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | -                | <b>-49,574.00</b>   |
| 9      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | <b>49,574.00</b> | <b>49,574.00</b>    |
| 10     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | <b>49,574.00</b> | -                   |



#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт                                                 | Тайлант оны           |                |             |        |
|------------|----------------------------------------------------------|-----------------------|----------------|-------------|--------|
|            |                                                          | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      | Зөрүү       | Хувь   |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         |                       | 49,574.00      | -           |        |
| I          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 425,067,600.00        | 425,117,174.00 | -           | 100.00 |
| II         | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 413,867,600.00        | 413,632,802.99 | 234,797.01  | 99.94  |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 79,851,200.00         | 79,728,800.00  | 122,400.00  | 99.85  |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 326,766,400.00        | 326,766,400.00 | -           | 100.00 |
| 210101     | Үндсэн цалин                                             | 303,996,400.00        | 303,996,400.00 | -           | 100.00 |
| 210102     | Нэмэгдэл                                                 | 20,770,000.00         | 20,770,000.00  | -           | 100.00 |
| 210103     | Унаа хоолны хөнгөлөлт                                    | 1,000,000.00          | 1,000,000.00   | -           | 100.00 |
| 210104     | Урамшуулал                                               | 1,000,000.00          | 1,000,000.00   | -           | 100.00 |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 7,250,000.00          | 7,137,602.99   | 112,397.01  | 98.45  |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал                                    | 7,250,000.00          | 7,137,602.99   | 112,397.01  | 98.45  |
| 2105       | Нормативт зардал зардал                                  | 14,800,000.00         | 14,800,000.00  | -           | 100.00 |
| 2105       | Хоол хүнс                                                | 14,800,000.00         | 14,800,000.00  | -           | 100.00 |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 18,100,000.00         | 18,100,000.00  | -           | 100.00 |
| 210401     | Бичиг хэрэг                                              | 1,600,000.00          | 2,307,960.00   | -707,960.00 | 144.25 |
| 210402     | Тээвэр, шатахуун                                         | 14,500,000.00         | 14,500,000.00  | -           | 100.00 |
| 210403     | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                       | 2,000,000.00          | 1,292,040.00   | 707,960.00  | 64.60  |
| 210404     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс              |                       |                | -           |        |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 9,100,000.00          | 9,100,000.00   | -           | 100.00 |
| 210601     | Багаж, техник хэрэгсэл                                   | 6,100,000.00          | 6,100,000.00   | -           | 100.00 |
| 210604     | Урсгал засвар                                            | 3,000,000.00          | 3,000,000.00   | -           | 100.00 |
| 2017       | Томилолт, зочны зардал                                   | 3,000,000.00          | 3,000,000.00   | -           |        |
| 210702     | Дотоод албан томилолт                                    | 3,000,000.00          | 3,000,000.00   | -           | 100.00 |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 851,200.00            | 728,800.00     | 122,400.00  | 85.62  |
| 210804     | Тээврийн хэрэгслийн оношилгоо                            | 40,000.00             | 40,000.00      | -           | 100.00 |
| 210805     | Тээврийн хэрэгслийн татвар                               | 493,000.00            | 370,600.00     | 122,400.00  | 75.17  |
| 210806     | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                          | 318,200.00            | 318,200.00     | -           | 100.00 |

ШШГЕГ-ын харьяа МСҮТ-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |                                                |                      |                      |               |        |
|-------------|------------------------------------------------|----------------------|----------------------|---------------|--------|
| 210807      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх         |                      |                      | -             |        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>         | <b>34,000,000.00</b> | <b>34,000,000.00</b> | -             | 100.00 |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх              | 34,000,000.00        | 34,000,000.00        | -             | 100.00 |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                        | <b>11,200,000.00</b> | <b>11,434,797.01</b> | - 234,797.01  | 102.10 |
| <b>2131</b> | <b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>         |                      | 1,560,797.01         | -1,560,797.01 |        |
| 213101      | Засгийн газрын дотоод шилжүүлэг                | -                    | 1,560,797.01         | -1,560,797.01 |        |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                  | <b>11,200,000.00</b> | <b>9,874,000.00</b>  | 1,326,000.00  | 88.16  |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 977,000.00           | 977,000.00           | -             | 100.00 |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал        | 10,223,000.00        | 8,897,000.00         | 1,326,000.00  | 87.03  |
| <b>1</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>          | 425,067,600.00       | 425,067,600.00       | -             | 100.00 |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>           | 425,067,600.00       | 425,067,600.00       | -             | 100.00 |
| 131001      | Улсын төсвөөс санхүүжих                        | 425,067,600.00       | 425,067,600.00       | -             | 100.00 |
| <b>9001</b> | <b>Удирдах ажилтан</b>                         | 1.00                 | 1.00                 | -             | 100.00 |
| 9002        | Гүйцэтгэх ажилтан                              | 33.00                | 29.00                | 4.00          | 87.88  |
| 9003        | Үйлчилгээний ажилтан                           | -                    | -                    | -             |        |

